



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ГАЗАРЗҮЙН МЭДЭЭЛЭЛ. ХИЛ ЗААГИЙН ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

MNS : 2021

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР
2021 ОН

ӨМНӨХ ҮГ

Стандарт, Хэмжил Зүйн Газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг.

Энэхүү стандартыг Монгол Улсын Засгийн газраас Үндэсний орон зайн өгөгдлийн талаар баримталж буй үзэл баримтлал, хөтөлбөрийн хүрээнд орон зайн өгөгдлийг цахимжуулах нэгдсэн систем бүхий геопорталын орон зайн өгөгдөл бүрдүүлэлт, солилцоотой холбоотой стандартын орчныг бий болгоход зориулсан өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлагыг энэхүү баримт бичигт тусган боловсруулав.

Стандарт боловсруулах ажлыг “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” сэдэвт төслийн хүрээнд стандарт боловсруулалтын багийн доктор Б.Баяртунгалаг, доктор Б.Сайнбуян, С.Амаржаргал, З.Нямбаяр, мэргэшсэн инженер Э.Алтанбагана нар хамтран гүйцэтгэв.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүн, Монгол Улсын зөвлөх инженер Ц.Дашзэвгэ редакц хийж, Монгол Улсын зөвлөх инженер Г.Нарантуяа шүүмжийг хийв.

Стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хамт олон, Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны гишүүд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон бусад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн мэргэжлийн байгууллагын хамт олонд талархал илэрхийлье.

Энэ стандартын төслийг ТХ-36/Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

Уг стандартыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006–ийн дагуу хянаж, боловсруулав.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар хот 13348 ШХ-48

Утас: (976-51) 263860

Факс: (976-11) 458032

Цахим шуудан: standardinform@masm.gov.mn

Цахим хуудас: www.estandart.gov.mn,

www.masm.gov.mn

СХЗГ 2021

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын Төв байгууллага) -т байна.

АГУУЛГА

ОРШИЛ	1
1 Хамрах хүрээ	2
2 Норматив эшлэл.....	2
3 Нэр томъёо, тодорхойлолт.....	3
3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт	3
3.2 Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт.....	4
4 Техникийн шаардлага	5
4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага	5
4.2 Атрибутад тавигдах (норматив) шаардлага	7
4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага.....	7
4.4 UML диаграмм (норматив) шаардлага.....	8
4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага.....	8
A хавсралт - Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга	9
B хавсралт - Кодын жагсаалт.....	52
C хавсралт - UML диаграмм.....	276
D хавсралт - Өгөгдлийн чанар	282

ОРШИЛ

Энэхүү стандартын зорилго нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг нэгдсэн мэдээллийн системд оруулах, бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, солилцох үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн сангийн бүтэц, агуулга, техникийн шаардлагыг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм.

Стандартыг баримталсны үр дүнд геопорталаар дамжуулан байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх, эрчимтэй хөгжих боломжийг олгоно.

Энэхүү стандарт нь нэг талаас орон зайн өгөгдлийн санг хариуцагч байгууллага нөгөө талаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй хамаарал бүхий үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, хадгалах, солилцох бүх харилцаанд үйлчилж нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах үндсэн баримт бичиг болно.

Стандартын техникийн шаардлагуудыг Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах Европын орон зайн мэдээллийн дэд бүтэц INSPIRE (Infrastructure for Spatial Information in Europe) системийн техникийн тодорхойлолт, олон улсын стандартын байгууллага (ISO)-ын TX 211 (ISO/TC 211-Geographic information/Geomatics) -с гаргасан ISO 19100 цуврал стандартуудын үзүүлэлт, шаардлагад тулгуурлаж, Монгол Улсад мөрдөж буй стандарт, норм, дүрэм, журам, орон зайн суурь өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэл болгон боловсруулав.

Мөн орон зайн суурь өгөгдлийн техникийн шаардлагуудыг мэдээллийн сангийн загварыг дүрслэх Загварчлалын Нэгдмэл Хэл (UML-Unified Modeling Language) -ийн дагуу нийцүүлэн боловсруулав.

Стандарт бүтэц нь орон зайн өгөгдлийн загвар, өгөгдлийн сангийн агуулга, орон зайн объектын төрөл, атрибут, кодын жагсаалт, UML диаграммаас бүрдэнэ.

Уг стандарт нь хил заагийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, тайлагнах, үйлчлэх зорилгоор өгөгдлийг системтэй, уялдаатай болгон бүрдүүлэхэд чиглэнэ.

Хил заагийн орон зайн суурь өгөгдлийн агуулга нь Монгол Улсын хил, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил, Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан тусгай хэрэгцээний газрын хил, хотын тэг горитог, ашигт малтмал, амьтны аймаг, уур амьсгал, байгалийн бүс бүслүүр, нийгэм, эдийн засгийн хил болон бусад хилийн мэдээллийг агуулна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 35.240.70

Газарзүйн мэдээлэл. Хил заагийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS ... : 2021
Geographic information. Data specification on Boundary	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны дугаар сарынний өдрийн дугаар тушаалаар батлав

Энэхүү стандарт нь батлагдсан өдрөөс эхлэн хүчинтэй.

Стандартын шаардлага нь заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Хил заагийн орон зайн суурь өгөгдлийн сан нь Монгол Улсын хил, засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил, тусгай хэрэгцээний газрын хил, бусад хил буюу ашигт малтмал, амьтны аймаг, уур амьсгал, байгалийн бүс бүслүүр, шуудангийн бүсчлэл гэх мэт хилүүд хамаарна.

Энэхүү стандарт нь хил заагийн орон зайн суурь өгөгдлийн сангийн бүтэц, стерео төрлүүд, атрибут мэдээллийн шаардлага, UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language), өгөгдлийн чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлоход хамаарна.

Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд хил заагийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, хөтлөх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжид хамаарна.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO 19107: 2005, Газарзүйн мэдээлэл – Орон зайн схем;

ISO 19108: 2005, Газарзүйн мэдээлэл – Цаг хугацааны схем;

ISO 19108-с, 2002/Cor 1: 2006, Газарзүйн мэдээлэл – Цаг хугацааны схем, Техникийн засвар 1;

ISO 19111: 2007, Газарзүйн мэдээлэл – Орон зайн тулгуур солбицол;

ISO 19113: 2005, Газарзүйн мэдээлэл – Чанарын зарчим;

ISO 19118: 2006, Газарзүйн мэдээлэл – Кодлолт;

ISO 19123:2007, Газарзүйн мэдээлэл – Багц давхаргын геометр ба функцийн схем

ISO 19125-1: 2004, Газарзүйн мэдээлэл – Энгийн биетийн хандалт - 1-р хэсэг: Нийтлэг архитектур;

ISO 19135: 2007, Газарзүйн мэдээлэл – Бүртгэлийн явц;

ISO 19138: 2006, Газарзүйн мэдээлэл – Өгөгдлийн чанарын хэмжүүр;

ISO/TS 19139: 2007, Газарзүйн мэдээлэл – Мета өгөгдөл - XML схемийн хэрэгжилт;

ISO/DIS 19157, Газарзүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар;

MNS 5774:2007 Газарзүйн мэдээлэл – Мета өгөгдөл

MNS ISO/TS 19104:2012 Газарзүйн мэдээлэл - Нэр томьёо

MNS 6702: 2017 Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг

Масштаб: 1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандарт ба түүнд холбогдох бусад стандартын хувьд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

Үндсэн агуулгад хамаарах ойлголт

3.1.1

орон зайн өгөгдөл

газрын гадарга дээрх болон доорх, ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил зааг, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогц

3.1.2

орон зайн суурь өгөгдөл

харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх, оролцогч талуудын хэрэгцээг нийтлэгээр хангах боломжтой, үндсэн буюу голлох мэдээлэл гэж тодорхойлсон орон зайн өгөгдөл

3.1.3

өгөгдлийн багц

өгөгдлийн сангийн нэг сэдэвчилсэн агуулгын хүрээнд багтах хэд хэдэн өгөгдлийн цуглуулга.

3.1.4

стерео төрөл

стандартад ашиглаж байгаа биет болон атрибутын ижил төстэй шинж чанарыг харгалзан үүсгэсэн ангилал, төрлийг.

3.1.5

өгөгдөл төрөл

ямар нэгэн геометр дүрслэл агуулаагүй, өгөгдлийн сэдэвчилсэн утга, хэмжээс, формат зэргийг илэрхийлэгч, хэд хэдэн үзүүлэлтүүдийг агуулсан төрлийг.

3.1.6

биет төрөл

орон зайн агуулга бүхий геометр биетээр дүрслэгдсэн болон дүрслэх боломжтой биетийг илэрхийлэгч төрлийг.

3.1.7

кодын жагсаалт

биетийн төрөл эсвэл өгөгдлийн төрлийн атрибутадад ашиглах урьдчилан боловсруулж үүсгэсэн ангиллын утгын жагсаалт.

3.1.8

домэйн

Тухайн сэдвийн үзүүлэлтийн агуулгын хүрээг илэрхийлнэ. Тухайлбал, хэмжээс /measure/ заасан утгын төрөлд “хэмжсэн тоон утга” л байх ёстой гэсэн шалгуур нь домэйн болохыг.

3.2

Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт

3.2.1

Boolean

Тухайн мэдээлэл үнэн эсвэл худлаа гэсэн хоёр боломжит утгын аль нэгийг сонгоход хэрэглэдэг утгын төрөл юм (ихэвчлэн тийм бөгөөд үгүй гэсэн төрөл ашигладаг). [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.3

Character string

Тэмдэгтийн мөр. Бичиглэхэд ашигладаг тэмдэгтүүдийн жагсаалт. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.4

Date time

Цаг хугацааг заасан утгын төрөл. Огноо, цагийн хослол хэлбэрээр байна. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.5

Identifier

Өгөгдөл мэдээллийг хариуцагч эрх бүхий байгууллагаас олгосон орон зайн объектын танигч буюу тодорхойлогч. Энэ нь тухайн өгөгдлийг бусад программ, системүүд лавлах, холбох үед ашиглана. [Дэлгэрэнгүй мэдээллийг: INSPIRE DS-D2.5]

3.2.6

GM_Object

Геометрийн объектын ангилал зүйн үндсэн анги бөгөөд газарзүйн хувьд хамааралтай бүх геометрийн объектуудыг төлөөлдөг. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

3.2.7

GM_MultiSurface

Олон гадаргуу бүхий геометр биет. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

3.2.8

GM_Curve

Тасралтгүй холбогдсон, муруй хэлбэрийн шугаман дүрслэл. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

3.2.9

Measure

Хэмжилтийн үр дүнд гаргасан хэмжигдэхүүний тоон утга. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.10


URL

Тухайн биетийн текстэн тэмдэгтээр илэрхийлсэн холбоосын утга. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO19136:2007]

4 Техникийн шаардлага

4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага

4.1.1 Орон зайн өгөгдлийн сан нь өгөгдлийг сэдэв, агуулгаас хамааруулан багцалсан хэлбэр болох “**өгөгдлийн багц**”, өгөгдлийн багц дотор агуулагдах стерео төрлүүд, өгөгдөл тус бүрийн дэлгэрэнгүй “**атрибут**”, атрибутанд орох мэдээллийг төрөлжүүлж ангилсан “**кодын жагсаалт**” гэсэн хэсгүүдээс тогтсон бүтэцтэй (1-р зурагт тоймлон үзүүлэв) байхыг шаардана.



1-р зураг – Хил заагийн өгөгдлийн сангийн бүтэц, агуулга

4.1.2 А хавсралтаар орон зайн өгөгдлийн сангийн багц тус бүрээр биет төрлүүд тэдгээрт хамаарах өгөгдөл төрөл, биет төрөл болон өгөгдөл төрлийн атрибут, атрибутын талбарт оруулах утга болон утгын төрлийн норматив шаардлагыг заана.

4.1.3 В хавсралтаар кодын жагсаалтын норматив шаардлагыг тодорхойлно. Кодын жагсаалт нь атрибутын талбарт оруулах утганд ашиглах тогтмол утга бүхий ангилал гэж ойлгоно.

4.1.4 Орон зайн өгөгдлийн сангийн багцад орсон өгөгдөл нь А хавсралтын А.1-р хүснэгтэд үзүүлсэн «биет төрөл», «өгөгдөл төрөл», «кодын жагсаалт» гэсэн стереo төрөлтэй байх норматив шаардлагыг хангана.

4.1.5 Биет төрөл тус бүрийн орон зайн дүрслэлийг А хавсралтын А.1-р хүснэгтэд “Биетийн төрөл” багананд үзүүлсэн шаардлагын дагуу дүрсэлнэ.

4.1.6 Өгөгдлийн нэрийг монгол, англи хэлээр нэрлэх бөгөөд мэдээллийг бүрдүүлэхдээ тодорхойлолтоор илэрхийлсэн агуулгын дагуу байхыг шаардана.

4.1.7 Хил заагийн орон зайн суурь өгөгдлийн сан нь А хавсралтын А.1-р хүснэгтийн дагуу **засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тусгай хэрэгцээний газрын хил, хот, суурин газрын хил, бусад хил** гэсэн 4 өгөгдлийн багцаас бүрдсэн байна.

4.1.8 Хил заагийн орон зайн өгөгдлийн санд 28 биет төрөл агуулна.

4.2 Атрибутад тавигдах (норматив) шаардлага

4.2.1 Өгөгдлийн атрибут мэдээлэл нь өгөгдөл тус бүрээр А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсэн норматив шаардлагыг хангана.

4.2.2 Атрибут нь А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсний дагуу атрибутын нэрийг монгол, /англи хэл/-ээр нэрлэх, “талбарт оруулах утга”, “утгын төрөл”, “тэмдэгтийн урт” гэсэн шаардлагыг хангахаас гадна тодорхойлолтод тусгасан мэдээллийн агуулгын дагуу бүрдүүлэлт, бичиглэлийг хийсэн байхыг шаардана.

4.2.3 Орон зайн өгөгдлийн сангийн биет төрөл нь давтагдашгүй гадаад танигч атрибутыг агуулах шаардлагатай. Гадаад танигч /External id/ нь орон зайн объектын танигч нь өгөгдлийн сангийн гадаад танигч үүсгэхэд ашиглах тусгай танигч код бөгөөд “дотоод танигч” /Local id/, “нэрийн талбар” /Name space/, “танигчийн хувилбар” /Version id/ гэсэн 3 атрибутаас бүрдэнэ [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005].

4.2.3.1 “Дотоод танигч /Local id/” нь тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.

4.2.3.2 “Нэрийн талбар /Name space/” нь өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

4.2.3.3 “Танигчийн хувилбар /Version id/” нь орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.

4.2.4 Хил заагийн орон зайн суурь өгөгдлийн сан нь 4.2.4.1 –д заасан “Газар зүйн нэр” /Geographical name/ орон зайн дэд өгөгдлийн сантай холбогдоно.

4.2.4.1 “Газар зүйн нэр” /Geographical name/ нь тухайн хил заагийн “Нэр” /Name/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утганд «Газар зүйн нэр» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газар зүйн мэдээлэл. Газар зүйн нэрийн өгөгдлийн үзүүлэлт MNS:2021” стандартаас авч ашиглана.

4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага

4.3.1 А хавсралтын А.1-р хүснэгтэд кодын жагсаалтын тодорхойлолт, В хавсралтад кодын жагсаалтын кодын утга, түүний тодорхойлолтын дагуу норматив шаардлагыг хангана.

4.3.2 Хил заагийн орон зайн өгөгдлийн санд 28 кодын жагсаалт агуулна.

4.3.3 А хавсралтын А.2 хүснэгтэд заасан атрибутын талбарт оруулах утганд заасан кодын жагсаалтын дагуу ангиллын утгыг сонгож оруулах нөхцлөөр ашиглана.

4.4 UML диаграмм (норматив) шаардлага

4.4.1 Орон зайн объектын төрөл, атрибут, утгын төрөл, тэдгээрийн холбоосыг С хавсралтад үзүүлсэн UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language)-ын дагуу өгөгдлийг загварчилна.

4.4.2 Орон зайн өгөгдлийг загварчлах, боловсруулалтыг автоматжуулах, хэрэглээний схемд суурилсан өөр өөр түвшний өгөгдлийг уялдуулахад С хавсралтад үзүүлсэн UML диаграммыг ашиглана.

4.4.3 С хавсралтад үзүүлсэн UML диаграммаас гадна хил заагийн орон зайн суурь өгөгдлийн сантай хамааралтай бусад орон зайн суурь өгөгдлийн сангийн UML диаграммыг ашиглахыг зөвшөөрнө.

4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага

4.5.1 Өгөгдлийн чанарт тавигдах шаардлага нь хил заагийн суурь орон зайн өгөгдлийн нэгжийн чанарыг үнэлэх, баримтжуулах зорилготой чанарын элементүүдийн шаардлагыг D Хавсралтын D.1.1 - D.1.6-р хүснэгтэд үзүүлснээр дагаж мөрдөнө. Эдгээр шаардлага нь ISO 19157 олон улсын стандартад заасан чанарын үзүүлэлтүүд бөгөөд энэ стандартад ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөнө.

4.5.2 Дэд бүтцийн суурь орон зайн өгөгдлийн сангийн өгөгдлийн нэгж болох багц, биет төрөл, өгөгдөл төрлүүд нь өгөгдлийн чанарын дараах ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангана. Үүнд:

4.5.2.1 Иж бүрдэл: биет болон тэдгээрийн атрибут, харилцан хамаарлуудын түвшин.

4.5.2.2 Утга агуулгын нийцтэй байдал: өгөгдлийн бүтэц, атрибут ба харилцан хамаарлуудын логик дүрмүүдийг баримтлах түвшин.

4.5.2.3 Байрлалын нарийвчлал: орон зайн объектын байрлалын нарийвчлалын түвшин.

ТӨГСӨВ

А Хавсралт
(норматив)

Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга

А. 1-р хүснэгт – Хил заагийн орон зайн суурь өгөгдлийн багц ба стерео төрлүүд

А.1.1 Өгөгдлийн багц: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж (Administrative units)

Д/д	Өгөгдлийн нэр	Стерео төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж <i>/Administrative unit/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Улс болон өөрийн удирдлага бүхий засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж /улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэс, баг хорооны хилийн зааг/ хамаарна.
2	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил <i>/Administrative boundary/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Шулуун	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийг илэрхийлсэн шугам /улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэс, баг хорооны хилийн зааг/.
3	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшин <i>/Administrative hierarchy level/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшин.
4	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төв <i>/Residence of authority/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Цэг	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төв.
5	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн үндсэн ангилал <i>/Administrative unit major class value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж /аймаг, нийслэл/.
6	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дэд ангилал <i>/Administrative unit sub class value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж /сум, дүүрэг/.
7	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн анхдагч ангилал <i>/Administrative unit primary class value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж /баг, хороо/.

А.1.2 Өгөгдлийн багц: Тусгай хэрэгцээний газрын хил суурь өгөгдөл (Boundary of specific necessity area)

Д/д	Өгөгдлийн нэр	Сtereo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Улсын тусгай хамгаалалттай газар /Protected sites/	«биет төрөл» /feature type/	Полигон	Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсаж өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалах зэрэг багтана.
2	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндсэн ангилал /Protected sites major class value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндсэн ангиллууд багтана.
3	Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд ангилал /Protected sites sub class value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндсэн ангиллуудын хамгаалалтын бүсүүд багтана.
4	ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн тэмдэглэгээний ангилал /Unesco world heritage designation value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн аль ангилалд багтаж байгааг илэрхийлнэ.
5	Улсын хилийн зурвас газар /State border zone/	«биет төрөл» /feature type/	Полигон	Улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, хилийн инженер, техникийн байгууламж барих зориулалтаар улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэ.
6	Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар /National defense and security area/	«биет төрөл» /feature type/	Полигон	Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бөгөөд хуульд заасан онцгой нөхцөл, горим, дэглэмийн дагуу тогтоосон газар.
7	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар /Foreign diplomatic and consulates area/	«биет төрөл» /feature type/	Полигон	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар.
8	Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	«биет төрөл» /feature type/	Полигон	Зориулалт бүхий талбай (усны харуулын талбай, хөдөө аж ахуйн ажиглалтын талбай, газар чичирхийллийн станц, зай хэмжлийн жишилтийн полигон, агаарын

	<i>/Experimental area of science and technology/</i>			зургийн полигон, гравиметрийн полигон, Монгол Улсын геодезийн эхлэл цэг, түүний дагалдах байгууламж, Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүдийн судалгааны талбай зэрэг) нь хүний болон бусад үйл ажиллагааны нөлөөлөлд өртөхөөргүй, зорилтот судалгааг хийх боломжийг хангасан газар байна.
9	Туршилт, судалгааны талбайн зориулалтын ангилал <i>/Experimental area type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Зориулалт бүхий туршилт, судалгаа хийж буй талбайн ангилал.
10	Аймаг дундын отрын бэлчээр <i>/Reserved pasture land/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Байгалийн давагдашгүй хүчин зүйл болох ган, зудын үед ашиглах боломжтой 1-2 аймгийн газар нутгийг дамнан байрлах бөгөөд ургамлын гарц сайтай, уст цэг хүрэлцээтэй газар байна.
11	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай <i>/Hayfield for state fodder fund/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Талбай нь бусад бэлчээртэй харьцуулахад 1 хонин толгойд ноогдох ургамлын гарц сайтай, уст цэг хүрэлцээтэй, газрын гадаргын налуу нь 0-6 градустай байна.
12	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай <i>/Contracted petroleum field/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гэрээлэгчийн хооронд байгуулсан гэрээ.
13	Чөлөөт бүсийн газар <i>/Free zone/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ.
14	Чөлөөт бүсийн хэлбэр, ангилал <i>/Free zone type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Чөлөөт бүсийн талбайн хэлбэрүүдийг агуулах ангилал.
15	Цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар <i>/Nuclear facility construction and use area/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Хүн ам, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр, хот суурин газар, ундны усны эх үүсвэрээс алслагдсан байх.

16	Бичил уурхайн зориулалтаар олгосон газар <i>/Artisanal mining area/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор нөхөрлөл болон хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагаа.
17	Бичил уурхайд олборлож буй ашигт малтмалын төрөл, ангилал <i>/Artisanal mining mineral type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Бичил уурхайд хувь хүмүүсийн олборлож буй ашигт малтмалын төрлүүд.
18	Хилийн боомтын бүс <i>/Border point zone/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хилийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийх зориулалтаар төхөөрөмжилсөн, тусгайлан тогтоосон газрыг оруулна.
19	Хилийн боомтын зэрэглэл <i>/Border point level type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Хилийн боомтын зэрэглэлийг илтгэсэн ангилал.
20	Хилийн боомтын зориулалтын ангилал <i>/Border dedication type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Хилийн боомтыг зориулалтаар нь ангилсан байдал.
21	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар <i>/Land for national development and infrastructure/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Тухайн улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд ашиг тустай стратегийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий этгээдийн шийдвэрт үндэслэж олгосон газар.
22	Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар <i>/Hazardous waste facility construction area/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа явуулах газар, уг зориулалтаар барилга байгууламж барихад тавигдах шаардлагыг хангасан байх хэрэгтэй.

А.1.3 Өгөгдлийн багц: Хот, суурин газрын хил суурь өгөгдөл (Boundary of urban and settlement area)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Хотын тэг горитог /City expansion boundary/	«биет төрөл» /feature type/	Полигон	Газрын нэгдмэл сангийн тооллогоор тогтоогдсон хот тосгон бусад суурин газрын хил заагийг тогтоосон байдал.
2	Хотын зэрэглэл, ангилал /Urban level type value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Хот, тосгоны зэрэглэлийг илтгэсэн ангилал.

А.1.4 Өгөгдлийн багц: Бусад хилийн суурь өгөгдөл (Other boundaries)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Байгалийн бүс, бүслүүрийн хил /Natural zone boundary/	«биет төрөл» /feature type/	Полигон	Тухайн орон нутгийн байгалийн нөхцөл, нөөц, уур амьсгал, ургамал, амьтан, хөрс зэрэг нэгнээсээ ялгаатай онцлог шинж чанар, шалгуур үзүүлэлтүүд нь орон зай, нутаг дэвсгэрийн ялгаатай бүсүүдийг үүсгэж байдаг.
2	Байгалийн бүс, бүслүүрийн ангилал /Natural zone type value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Байгалийн бүс, бүслүүрийн ялгаатай байдлыг илэрхийлэх ангилал.
3	Ашигт малтмалын ордын хил /Mineral deposit boundary/	«биет төрөл» /feature type/	Полигон	Геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадарга, түүний хэвлийд бүрэлдэн тогтож чанар, нөөц нь тодорхойлогдсон, үйлдвэрийн аргаар олборлоход эдийн засгийн хувьд ашигтай эрдсийн хуримтлалын хамрах хүрээ гэж ойлгоно.
4	Ашигт малтмалын ордын зэрэглэл /Mineral deposit level type value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Ашигт малтмалын ордын зэрэглэлийг харуулсан ангилал.
5	Ашигт малтмалын төрөл, ангилал /Mineral type value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Түгээмэл олборлодог ашигт малтмалын төрөл, ангилал.
6	Ан амьтны тархцын хил /Wildlife distribution boundaries/	«биет төрөл» /feature type/	Полигон	Тухайн амьтны нутагладаг, нүүдэллэдэг, тэдгээрийн амьдрах тохиромжтой нөхцөл бүрдсэн газар нутгийг хэлнэ.
7	Ан амьтдын ангилал /Animals class value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Ан амьтдын тархац, байршлыг илэрхийлэх ангилал.

8	Уур амьсгалын хил <i>/Climatic boundary/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Уур амьсгал бүрэлдэхэд тухайн орон нутгийн газарзүйн байрлал, нарнаас ирж буй дулааны илч, агаарын орчил урсгал, газрын гадаргын хэв шинж зэрэг бие биетэйгээ нягт холбоотой хүчин зүйлс голлон нөлөөлж хил заагийг үүсгэдэг.
9	Уур амьсгалын бүсийн ангилал <i>/Climatic zone type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Уур амьсгалын бүсийн ангилал.
10	Уур амьсгалын дэд бүсийн ангилал <i>/Climatic sub zone type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Уур амьсгалын дэд бүсийн ангилал.
11	Эдийн засгийн бүс <i>/Economic zone/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор үндэсний хэмжээнд, бүс нутгийн хөгжлийг түргэтгэх, тодорхой нутгийн түвшинд эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай бодлого явуулах шаардлагыг харгалзан тогтоосон нутаг дэвсгэрийн зааг хүрээг хэлнэ.
12	Эдийн засгийн бүсийн ангилал <i>/Economic zone type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор эдийн засгийн бүсүүдэд хуваасан ангилал.
13	Усны сав газар <i>/River basins/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Гадаргын ус хурах талбай болон газрын доорх усны нөөцийг бүрдүүлэх тэжээгдлийн муж, тархалтын талбайг хамарсан орон зайг хэлнэ.
14	Гол мөрний ай савын ангилал <i>/River basins major class value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Гол мөрний аль ай савд багтаж байгааг илтгэх ангилал.
15	Гол мөрний сав газрын ангилал <i>/River basins sub class value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Гол мөрний сав газруудыг илтгэх ангилал.
16	Газрын үнэлгээний бүсчлэл <i>/Land valuation zone/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Газрын суурь үнэ, төлбөрийн хэмжээг тогтоох, газрын өгөөжийг тодорхойлох зорилгоор газрын үнэлгээний бүсчлэлийг тогтооно.
17	Газрын үнэлгээний бүсчлэлийн ангилал <i>/Land valuation zone type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Газрын суурь үнэ, төлбөрийн хэмжээг тогтоох зорилгоор гаргасан газрын үнэлгээний бүсчлэлийн ангилал.
18	Сонгуулийн тойргийн хил <i>/Constituency boundary/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Сонгуулийн үр дүнг тодорхойлон гаргах нутаг дэвсгэрийг сонгуулийн тойрог гэнэ. Тойрог нь улс,

				аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд нэгдсэн дугаартай байна.
19	Сонгуулийн тойргийн хилийн ангилал <i>/Constituency boundary type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Сонгуулийн үр дүнг тодорхойлон гаргах сонгуулийн тойргуудыг харуулсан ангилал.
20	Шуудангийн бүсчлэлийн хил <i>/Postal zone/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Бүсчлэлийн кодыг Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн хуваарийн дагуу засаг захиргааны нэгжийн болон хот суурингийн хэсэг (бүс)-ийн байршлын тухай мэдээллийг агуулж, тэдгээрийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан зохицуулалт хийх, давхардуулан оноогдохгүйгээр, оноох нөөц бүхий 5 оронтой тоогоор илэрхийлдэг.
21	Шуудангийн бүсчлэлийн үндсэн ангилал <i>/Postal zone major class value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Бүсчлэлийн хуваарийн дагуу засаг захиргааны нэгжийн байршлын тухай мэдээллийг агуулсан шуудангийн бүсчлэлийн үндсэн ангилал.
22	Шуудангийн бүсчлэлийн дэд ангилал <i>/Postal zone sub class value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Бүсчлэлийн хуваарийн дагуу засаг захиргааны нэгжийн байршлын тухай мэдээллийг агуулсан шуудангийн бүсчлэлийн дэд ангилал.
23	Шуудангийн бүсчлэлийн анхдагч ангилал <i>/Postal zone primary class value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Бүсчлэлийн хуваарийн дагуу засаг захиргааны нэгжийн байршлын тухай мэдээллийг агуулсан шуудангийн бүсчлэлийн анхдагч ангилал.
24	Хамгаалалтын бүс <i>/Protection zone/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Тодорхой хамгаалалтын бүс тогтоох шаардлагатай байгалийн болон хүний гараар бүтсэн биетүүдийн нөөц, эх үүсвэрийг хамгаалах, зохистой ашиглах, хомсдох, бохирдохоос сэргийлэх, нөхөн сэргээх, аюул ослоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг хамааруулна.
25	Хамгаалалтын бүсийн ангилал <i>/Protection zone type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Байгалийн болон хүний гараар бүтсэн биетүүдийг хамгаалах зорилгоор бүс тогтоосон ангилал.

А. 2-р хүснэгт - Орон зайн өгөгдлийн дэд сангийн давхаргын атрибутын агуулга

А.2.1 Өгөгдлийн багц - Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн суурь өгөгдөл (Administrative units)

А.2.1.1 Биет төрлийн нэр: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж (Administrative unit)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Олон талт гадаргуу /GM_MultiSurface/	-	-	Орон зайн объектын геометр дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Засаг захиргааны нэгжийн ашиглаж эхэлсэн хугацаа.
8	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Засаг захиргааны нэгжийн ашиглалт дууссан цаг хугацаа.

9	Нэр /Name/	«Газар зүйн нэр» «Geographical name»	-	-	Шаардлагатай тохиолдолд хэд хэдэн хэлээр өгөгдсөн засаг захиргааны нэгжийн албан ёсны газарзүйн нэр.
10	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн үндсэн ангилал /Administrative unit major class/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн үндсэн ангилал /Administrative unit major class value/	-	-	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн аймаг, нийслэлийн ангилал. * MNS 5641-1 : 2006 Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код. 1-р хэсэг: Аймаг, нийслэл, стандартын ангиллыг ашиглав. Энэхүү хил заагийн стандарт нь батлагдсан хугацааны ангиллыг ашигласан бөгөөд хэрэв стандартын ангилал болон жагсаалт шинэчлэгдэж өөрчлөгдсөн тохиолдолд түүнийг дагаж мөрдөнө.
11	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дэд ангилал /Administrative unit sub class/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дэд ангилал /Administrative unit sub class value/	-	-	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн сум, дүүргийн ангилал. * MNS 5641-2 : 2006 Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код. 2-р хэсэг: Сум, дүүрэг, стандартын ангиллыг ашиглав. Энэхүү хил заагийн стандарт нь батлагдсан хугацааны ангиллыг ашигласан бөгөөд хэрэв стандартын ангилал болон жагсаалт шинэчлэгдэж өөрчлөгдсөн тохиолдолд түүнийг дагаж мөрдөнө.
12	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн анхдагч ангилал /Administrative unit primary class/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн анхдагч ангилал /Administrative unit primary class value/	-	-	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн баг, хорооны ангилал. * MNS 5641-3 : 2006 Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код. 3-р хэсэг: Баг, хороо, стандартын ангиллыг ашиглав. Энэхүү хил заагийн стандарт нь батлагдсан хугацааны ангиллыг ашигласан бөгөөд хэрэв стандартын ангилал болон жагсаалт шинэчлэгдэж өөрчлөгдсөн тохиолдолд түүнийг дагаж мөрдөнө.

13	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшин /National level/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшин /Administrative hierarchy level/	-	-	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшин. Administrative hierarchy level - кодын жагсаалтын утгаас авч ашиглана.
----	---	---	---	---	---

А.2.1.2 Биет төрлийн нэр: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил (Administrative boundary)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Муруй /GM_Curve/	-	-	Хилийн шугамын геометр дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ангилал /Administrative unit primary class/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн анхдагч ангилал /Administrative unit primary class value/	-	-	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн баг, хорооны ангилал. Administrative unit primary class value - кодын жагсаалтын утгаас авч ашиглана.

8	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшин /National level/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшин /Administrative hierarchy level/	-	-	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшин. Administrative hierarchy level - кодын жагсаалтын утгаас авч ашиглана.
---	--	--	---	---	---

А.2.1.3 Биет төрлийн нэр: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төв (Residence of authority)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Олон талт гадаргуу /GM_MultiSurface/	-	-	Орон зайн объектын геометр дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Нэр /Name/	«Газар зүйн нэр» «Geographical name»	-	-	Засаг захиргааны оршин буй байрлалын нэршил.
8	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ангилал /Administrative unit primary class/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн анхдагч ангилал	-	-	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн баг, хорооны ангилал.

		/Administrative unit primary class value/			Administrative unit primary class value - кодын жагсаалтын утгаас авч ашиглана.
9	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшин /National level/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшин /Administrative hierarchy level/	-	-	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшин. Administrative hierarchy level - кодын жагсаалтын утгаас авч ашиглана.

А.2.2 Өгөгдлийн багц –Тусгай хэрэгцээний газрын хил суурь өгөгдөл (Boundary of specific necessity area)

А.2.2.1 Биет төрлийн нэр: Улсын тусгай хамгаалалттай газар (Protected sites)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Олон талт гадаргуу /GM_MultiSurface/	-	-	Тусгай хамгаалалттай газар нутгийн хил хязгаарыг тодорхойлсон геометр дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.

7	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Тусгай хамгаалалттай газар нутгийг хууль ёсны дагуу үүсгэн байгуулсан огноо. Энэ нь мэдээллийн системд тусгай хамгаалалттай газрыг оруулсан бус бодит байдал дээр албан ёсоор бий болгосон огноо юм.
8	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Тусгай хамгаалалттай газар нутгийг хууль ёсны дагуу хүчингүйд тооцсон огноо.
9	Хууль ёсны баримт бичиг /Legal foundation document/	Холбоос /URL/	Холбоос /URL/	100	Албан ёсоор эрх бүхий байгууллагаас улсын тусгай хамгаалалттай газрыг баталсан хууль эрх зүйн актын баримт бичиг.
10	Тусгай хамгаалалттай газар нутгийн нэр /Site name/	«Газар зүйн нэр» «Geographical name»	-	-	Тусгай хамгаалалттай газар нутгийн нэр.
11	Талбай /Area/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	5	Тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн ерөнхий хэмжээ.
12	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндсэн ангилал /Protected sites major class/	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндсэн ангилал /Protected sites major class value/	-	-	Хамгаалалтад авсан зорилгод үндэслэсэн ангилал. Protected sites major class value - кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
13	Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд ангилал /Protected sites sub class/	Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд ангилал /Protected sites sub class value/	-	-	Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд ангилал. Protected sites sub class value - кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
14	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ангилал /Administrative unit sub class/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дэд ангилал /Administrative unit sub class value/	-	-	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн сум, дүүргийн ангилал. Administrative unit sub class value - кодын жагсаалтын утгаас авч ашиглана.
15	Рамсар /Ramsar/	Логик /Boolean/	Логик /Boolean/	5	Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц.

16	Биосферийн нөөц /Biosphere reserve/	Логик /Boolean/	Логик /Boolean/	5	ЮНЕСКО ба биосферийн программын биосферийн нөөцөд орсон эсэх.
17	ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн тэмдэглэгээний ангилал /UNESCO world heritage/	ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн тэмдэглэгээний ангилал /UNESCO world heritage designation value/	-	-	ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн аль ангилалд багтсан тухай тодорхойлно. UNESCO world heritage designation value - кодын жагсаалтаас авч ашиглана.

А.2.2.2 Биет төрлийн нэр: Улсын хилийн зурвас газар (National boundary stricted area)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Олон талт гадаргуу /GM_MultiSurface/	-	-	Улсын хилийн зурвас газрын хил хязгаарыг тодорхойлсон геометр дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Хууль ёсны дагуу үүсгэн байгуулсан огноо. Энэ нь мэдээллийн системд оруулсан бус

					бодит байдал дээр албан ёсоор бий болгосон огноо юм.
8	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Хууль ёсны дагуу хүчингүйд тооцсон огноо.
9	Хууль ёсны баримт бичиг /Legal foundation document/	Холбоос /URL/	Холбоос /URL/	100	Албан ёсоор эрх бүхий байгууллагаас тусгай хэрэгцээний газрыг баталсан хууль эрх зүйн актын баримт бичиг.
10	Талбай /Area/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	5	Улсын хилийн зурвас газрын талбайн ерөнхий хэмжээ.

А.2.2.3 Биет төрлийн нэр: Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар (National defense and security area)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Олон талт гадаргуу /GM_MultiSurface/	-	-	Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий газрын хил хязгаарыг тодорхойлсон геометр.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.

